

Өвөрхангай аймагт хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийн жагсаалт

№	Төслийн байгууллагын нэр	Төслийн салбар нэр	Эхлэх дуусах он	Үйл ажиллагааны, хэрэгжилт, санхүүжилт
1.	Боловсролын чанарын шинэчлэл	Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр	2019-2020 он	Бага боловсролд тулгамдаж буй “Нэгдүгээр ангийн суралцагчийн сургалтын үйл ажиллагаанд дасан зохицох чадварыг дэмжих”, “Дотуур байранд амьдарч буй бага ангийн сурагчдын сурлагын амжилтыг хичээлийн бус цагаар дэмжих”, “Суралцагсад ялгавартай хандах арга зүй аргачлалыг туршин хэрэгжүүлэх”, “Бага ангийн багшийг ажлын байранд нь хэрэгцээнд нь тулгуурлан хөгжүүлэх, бусдаас суралцах боломжийг нэмэгдүүлэх, туршлага судлах”, “Бага боловсролын сургалтын менежерүүдийг чадавхжуулах” гэсэн 5 чиглэлээр бага ангийн багш, сургалтын менежер, бага боловсролын мэргэжилтний бичсэн нийт 339.5 сая төгрөгийн санхүүжилт бүхий 20 төсөл 14 сургууль дээр хэрэгжиж байна.
2.	Японы хүүхдийг ивээх сан	Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь	2018-2021 он	Өвөрхангай аймгийн эмзэг бүлгийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ЯХИС-аас хэрэгжүүлж буй төсөл нь Арвайхээр сумын ЕБ-ын II сургууль, Арвайхээр сумын насан туршийн нэгж, Уянга сумын ЕБ-ын I сургууль, Уянга сумын насан туршийн нэгжид тус тус хэрэгжиж байна. Хэрэгжих хугацаандаа төсөл гардан хэрэгжүүлэгч бага ангийн багш нар, төслийн үр шимийг хүртэгч бага ангийн сурагчид, тусгай бүлгийн сурагчид, тэдний эцэг эх, сургуулийн удирдлага, заах аргын нэгдлийн ахлагч, сурагчдын төлөөлөл, ард иргэд давхардсан тоогоор нийт 30000 гаруй иргэдэд төслийн үзэл баримтлалыг таниулах сургалт мэдээллийг зохион байгуулж, хүүхэд хөгжлийн танхим, зорилтот бүлгүүдэд чиглэсэн гэрээр боловсрол олгох сургалт, техник хэрэгсэлд нийт 120 гаруй сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна.

3.	Германы сэргээн босголтын банкны “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл	“Бүс нутгийн аялал жуулчлалыг нутгийн иргэдэд түшиглэн тогтвортой хөгжүүлэх” төсөл	2017-2020 он	Жуулчдын зорин очих дуртай газруудын төлөвлөлтийг сайжруулах хүрээнд аймгийн аялал жуулчлалын бүс нутаг Орхоны хөндийд Германы “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн дэмжлэгтэйгээр авто машины зогсоол, мэдээллийн самбар, ариун цэврийн байгууламж бүхий отголох цэгүүдийг Хархорин сум, Төвхөн хийд, Улаан цутгалан орчимд байгуулсан. Мөн Төвхөн хийдийн угтах орчныг тохижуулах ажил хийдсэн. Үүнд стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж, хогийн сав, ширээ сандал, мэдээллийн самбар, замын тэмдэг тэмдэглэгээ зэргийг байршуулсан. 300.0 сая төгрөг
4.	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн Худалдааны байгууллага	“Малыг ялган тэмдэглэх, бүртгэх, системийг сайжруулах” туршилтын төсөл	2019-2021 он	Уянга, Бат-Өлзий, Баянгол, Гучин-Ус сумдад 190,0 мянган мал ээмэгжүүлэх малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулах

5.	Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сан	Хичээлийн хэрэгсэл хөтөлбөр	2019-2020 он	Өвөрхангай аймгийн хэмжээнд зорилтот өрхийн нийт 500 нэгдүгээр ангид орох хүүхдэд хичээл хэрэгсэл хангах төслийг дэмжсэн. Арвайхээр сумын хэмжээнд 160 хүүхдэд хичээлийн хэрэгсэлийг 2019.08.30 гардуулж өгсөн болно.
6.	Япон Улсын элчин сайдын яам Өвсний үндэс хөтөлбөр/	Өвсний үндэс хөтөлбөр	1997-2020 он	Япон улсын өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд Сант сумын сургуулийн дотуур байрны өргөтөл засварын ажил шийдвэрлэх шатанд явж байна.
7.	Монгол Улсад суух Австралийн элчин сайд яам	Жижиг бичил төсөл	2017-2020 он	Австрали улсын Элчин сайдын яамны жижиг төслийн буцалтгүй тусламжаар Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд үйл ажиллагаа явуулдаг /"Арвин Шунхлай" хоршоо нь 2017 онд малын арьс, шир боловсруулах үйлдвэр, 2019 онд "Ундрах баян ирээдүй" эко оёдлын цех зэрэг төслүүд амжилттай хэрэгжиж байна. Цаашид 2020 онд энэхүү жижиг төслийн хөтөлбөр хэрэгжинэ.
8.	Азийн хөгжлийн банк	Эко жорлон төсөл	2019-2020 он	Азийн хөгжлийн банкнаас гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг эко оо болгох төслийг Өвөрхангай аймгийн Арвайхээр суманд 200 айл өрхийн түвшинд хэрэгжүүлсэн.2020 онд энэхүү төсөл үргэлжилнэ.

9.				2017 оноос Өвөрхангай аймгийн 5 суманд энэхүү төсөл нь эхэлсэн. Төслийн хүрээнд
----	--	--	--	---

	Швейцарын хөгжлийн агентлага	“Ногоон алт” төсөл хөдөө аж ахуй	2017-2020 он	Бэлчээр хамгаалалт, зохистой ашиглалтыг сайжруулах, малчдын оролцоог дэмжих, малчдыг хуримтлалын сантай болгох чиглэлээр өргөн хүрээнд төсөл амжилттай хэрэгжиж байна.
10.	НҮБ-н Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл	2019-2021 он	<p>Уг төсөл нь иргэдийн орлогыг нэмэгдүүлж, Амжиргааг тогтвортой дээшлүүлэх зорилготой. Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд: <u>Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь</u></p> <p>Бэлчээрийн менежментийг сайжруулж, тэдний уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавхыг нэмэгдүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийж ажиллаж байна.</p> <p><u>2. Зах зээлийн хөгжил</u></p> <p>Хөдөөгийн эмэгтэйчүүдийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлж зах зээлд нэвтрэхэд нь дэмжлэг үзүүлэх, бүлэг байгуулж төслийн зээлд хамруулан тэднийг байнгын өрхийн орлоготой болгож амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглэсэн ажлууд хийгдэж байна.</p> <p><u>3. Бизнесийн орчин сайжруулах, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх</u></p>

				<p>Брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэхтэй холбоотой бизнесийн орчинг сайжруулах зорилгоор хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хоршоо, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжих, санхүүгийн батлан даалт бүхий зээл олгохоор чиглэл чиглэлээр нь сургалтанд хамруулах ажлууд хийгдсэн.</p>
--	--	--	--	--

--oOo--